



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

“Баянхайрхан” ХК-ийн үнэт цаасны  
арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баянхайрхан” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. “Баянхайрхан” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Компанийн үйл ажиллагааг сэргээхээр боловсруулсан бизнес төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн тайланг 2013 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэх, 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дахь данс нь нээгдээгүй хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Баянхайрхан” ХК /Ц.Дэлгэрмөрөн/-д үүрэг болгосугай.

4. Үнэт цаасны арилжааг сэргээж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Баянхайрхан” ХК /Ц.Дэлгэрмөрөн/-д үүрэг болгосугай:

1/ Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллах;


2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн

001730

мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөж ажиллах.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН